



**ХЭНТИЙ АЙМГИЙН
МӨРӨН СУМЫН ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧИЙН ТУШААЛ**

2026 оны 01 сарын 02 өдөр

Дугаар 6/01

Мөрөн сум

Бүтэц орон тоо батлах тухай

Монгол Улсын Боловсролын ерөнхий хуулийн 33 дүгээр зүйлийн 33.3.1, Хөдөлмөрийн тухай хуулийн 106 дугаар зүйлийн 106.1, 106.4 дахь заалт, Боловсрол Соёл Шинжлэх Ухааны сайд, Сангийн сайдын хамтарсан 2024 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн А/85, А/34 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус цэцэрлэгт ажиллах багш ажилчдын норм нормативыг дараах орон тоонд 2026 оны төсөвт багтаан хавсралтаар баталсугай. Үүнд:

Удирдах ажилтан – 1

Гүйцэтгэх ажилтан – 7


Үйлчлэх ажилтан – 6

2. Дээрх орон тоонд багтаан цалин хөлс, урамшуулал бусад холбогдох нэмэгдлийг хуульд заасан журмын дагуу бодож олгохыг нягтлан бодогч (Ц.Уугантуяа)-д зөвшөөрсүгэй.

ЭРХЛЭГЧ  Д. ПҮРЭВЖАРГАЛ



Мөрөн сумын цэцэрлэгийн эрхлэгчийн
2026 оны 01 дугаар сарын 02 ны өдрийн
6/01 дугаар тушаалын хавсралт



Албан тушаалын жагсаалт

№	Албан тушаал	Тоо	Зэрэглэл	Ажлын чиг үүрэг
1.	Эрхлэгч	1	ТҮБД-5	Төрөөс СӨБ-ын талаар баримтлах бодлого, Боловсролын тухай багц хууль, төсвийн болон бусад холбогдох хуулийг хэрэгжүүлэх, удирдлагаар хангах
2.	Багш	3	ТҮБД-4	Хүүхэд бүрийн зүй ёсны хөгжлийг хувийн онцлог, хэрэгцээнд нь нийцүүлэн асран хамгаалах үйл ажиллагаа, хөгжүүлж, хүмүүжүүлэх сургалтын хөтөлбөрөөр дэмжин насан туршийн боловсролын суурь чадвар эзэмшүүлнэ.
3.	Багшийн туслах	3	ТҮБД-1	Хүүхэд бүрийн онцлог хэрэгцээнд нийцүүлэн асран хамгаалах, хөгжүүлж хүмүүжүүлэхэд чиглэсэн бүлгийн багшийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах
4.	Нягтлан бодогч	0.5	ТҮМ-7	Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, бусад тогтоомж, заавар журам, стандартын дагуу байгууллагын албан хаагчдыг эд хөрөнгө болон бусад холбогдох материалаар тасралтгүй хангах үйл ажиллагаа явуулах, анхан шатны бүртгэлийг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах
5.	Нярав	1	ТҮ-4	Цэцэрлэгийн барилга болон эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын бүрэн бүтэн байдалд хяналт тавих, байгууллагын материаллаг бааз, хүүхдийн хоол хүнсийг бүрэн хангах, хоол хүнсийг өдөр тутам бичилт хийх, тайлан мэдээг гаргах
6.	Тогооч	1	ТҮ-3	Ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагыг бүрэн хангасан, технологийн заавар, нормын дагуу боловсруулсан хоол, хүнсээр хүүхдэд үйлчлэн тэдний хөгжлийн онцлог, хэрэгцээнд тохирсон нэмэлт үйлчилгээ үзүүлж, багш, ажилтан, эцэг эх, асран хамгаалагчдын хоол хүнс, шим тэжээлийн боловсролыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх
7.	Гал тогооны туслах ажилтан	1	ТҮ-1	Хүүхдийн насанд тохирсон олон нэр төрлийн хоол хүнсээр үйлчлэхэд тогоочийн ажилд туслах, ариун цэвэр халдвар хамгааллыг бүрэн хариуцна.
8.	Үйлчлэгч	1	ТҮ-1	Хүүхэд хөгжил эрүүл аюулгүй, ариун цэвэр, халдвар хамгааллын дэглэмийг сахин биелүүлж, байгууллагын соёлыг хамгаалах
9.	Жижүүр	2	ТҮ-1	Цэцэрлэгийн байрны доторх болон гаднах талбайн эд хөрөнгийн бүрэн бүтэн байдал, засвар үйлчилгээ, эрүүл ахуйн ажиллагаа, багш ажилчдын цаг ашиглалт, хүүхэд эцэг эхчүүдийн хөдөлгөөнд хяналт тавих